

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ(Сонгох даалгавар)

Санамж:

1. Зохиолын хэсгийг анхааралтай уншиж ойлгоорой.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Сонгож авсан үг, өгүүлбэрийг зохиолын хэсгийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Дөчин нэгэн хунгийн дууль

Намрын сэрүү орж, шувууд нутаг буцах болжээ. Харсаар байтал сүргээсээ нэг хун нь өдлөн нисэж чадахгүй болсныг улаан бургаст бүрдийн хөвөөг олон жил сахисан өвгөн эмгэн хоёр хараад, хөөрхий амьтныг араг хөмрөн барьж, гэртээ аваачин, хугарсан далийг нь чиг барин боожээ. Хөх бүрдэд хөхөө өвлийн гурван сар нэг мэдэхэд л өнгөрч, хаврын урь улаан бургасны үзүүрт гөлөглөн бултайж ирэхэд, өвөлжсөн хун өвгөн эмгэн хоёрын үр хүүхэд нь мэт дасаад, эдгэрсэн жигүүрээ тэнгэрт тэнийлгэн нисээд, бор гэртээ эргэн ирж, утаа үнэртсэн тулгат галын дэргэд жигүүрээ ээн хэвтэж байх дуртай болжээ.

Хаврын нэгэн хуйсгануур өдөртэнгэрийн цээлийг утас шиг сүвлэж, цагаасаа эрт ирсэн хунгийн сүрэг тонон дээгүүр нь хэдэнтээ ганганан эргэлдээд бүрдийн уснаа цагаан цэцэг мэт буувай. Цагаан лянхуа дэлгэрсэн шиг тэр хүрээлэн дунд хар цэцэг шиг ганц хун нисэж буухыг өхөөрдөн харах өвгөн эмгэн хоёрын дээгүүр өдөр сар нисэн өнгөрч, тэрхүү шамбалын оронд нэг л мэдэхэд сэрүү унаад, тооноор цас бударганасан намрын зэврүүн өдөр дөчин нэгэн хун бүрдээ нар зөв тойрон эргэлдсээр тэнгэртээ өндөр авчээ.

Орчлон хорвоогийн гайхамшигт тэрхүү эгшнүүдийг өвгөн эмгэн хоёр тольдон харж ахуйд хошууран далд орж байсан сүргээ орхин нэгэн хун эргээд нисчхэв гэнээ.

Мөнөөх ганц хун өвгөн эмгэн хоёрын бор гэрийн утаат тонон дээгүүр хэдэнтээ эргэлдэн бүхийд хунгийн сүрэг араас нь нэхэн ирж, ганц хунг аван хайлаад өөрийн цуваандаа эрхи шиг хэлхэн замдаа шулуудвай.

(Г.Мэнд-Ооёо)

Үгийн тайлбар: цээл-хязгааргүй уужим, уудам орон зай
бүрд-газраас ундран гарч, хол урсахгүй тогтсон хонхор газар

1. Өвгөн эмгэн хоёр ямар тустай үйл хийв?
 - A. Утаа үнэртсэн тулгат галаа түлсэн
 - B. Бүрдийнхөвөөг олонжилсахисан
 - C. Хугарсан далийг нь чиг барин боосон
 - D. Хар цэцэг шиг ганц хун нисч буухыг харсан
 - E. Гайхамшигт тэр эгшнүүдийг тольдон харсан
2. Хун яагаад эргээд ниссэн бэ?
 - A. Бусад хунгийн адил нисэж чадахгүй учраас эргээд ниссэн.
 - B. Эдгэрсэн жигүүрээ тэнгэрт тэнийлгэн нисэх дуртай учраас эргээд ниссэн.
 - C. Өвгөн эмгэн хоёрт үр хүүхэд нь мэт дассан учраас эргээд ниссэн.
 - D. Бор гэрийн утаат тонон дээгүүр эргэлдэн нисэхийн тулд эргээд ниссэн.
 - E. Өвгөн эмгэн хоёр гайхамшигт эгшнүүдийг харсан учраас эргээд ниссэн.
3. Эхийн өрнөл хэсгийн утгад **хамааралгүй** үгийг сонгоорой.
 - A. Гөлөглөн бултайж...
 - B. Ээн хэвтэх...
 - C. Ганганан эргэлдээд...
 - D. Өндөр авчээ...
 - E. Нисэж чадахгүй...
4. Дүрслэх хэрэглүүр **илрээгүй** хэсгийг сонгоно уу.
 - A. Тэнгэрийн цээлийг утас шиг сүвлэж...
 - B. Цагаан лянхуа дэлгэрсэн шиг тэр хүрээлэн дунд...
 - C. Орчлон хорвоогийн гайхамшигт тэр эгшнүүд...
 - D. Хар цэцэг шиг ганц хун нисэж...
 - E. Хунг аван хайлаад өөрийн цуваандаа эрхи шиг хэлхэн нисэв.

5. Эхийн сэдвийг тодорхойлоорой.
- A. Хүн байгалийн харьцааны тухай
C. Байгалийн тухай
E. Хөдөөгийн хүмүүсийн тухай
- B. Эх орны тухай
D. Шувуудын амьдралын тухай
6. “Хүн хүний хайранд дасна
Хун хүний сэтгэлд дасна” гэсэн гол санааг илэрхийлсэн хэвшмэл хэлцийн утгыг илэрхийлэх тулгуур өгүүлбэрийг олоорой.
- A. Бүрдийн хөвөөг олон жил сахисан өвгөн эмгэн хоёр хараад, хөөрхий амьтныг араг хөмрөн барьж, гэртээ аваачин, хугарсан далийг нь чиг барин боожээ
B. Орчлон хорвоогийн гайхамшигт тэрхүү эгшнүүдийг өвгөн эмгэн хоёр тольдон харж ахуйд хошууран далд орж байсан сүргээ орхин нэгэн хун эргээд нисчхэв гэнээ.
C. Хунгийн сүрэг араас нь нэхэн ирж, ганц хунг аван хайлаад, өөрийн цуваандаа эрхи шиг хэлхэн замдаа шулуудвай.
D. Тооноор цас бударганасан намрын зэврүүн өдөр дөчин нэгэн хун бүрдээ нар зөв тойрон эргэлдсээр тэнгэртээ өндөр авчээ.
E. Цагаан лянхуа дэлгэрсэн шиг тэр хүрээлэн дунд хар цэцэг шиг ганц хун нисэж буухыг өхөөрдөн харах өвгөн эмгэн хоёрын дээгүүр өдөр сар нисэн өнгөрч...
7. “Орчлон хорвоогийн гайхамшигт тэрхүү эгшнүүдийг өвгөн эмгэн хоёр тольдон харж ахуйд хошууран далд орж байсан сүргээ орхин нэгэн хун эргээд нисчхэв гэнээ” гэж бичсэнээр зохиолч юуг хэлэхийг хүссэн бэ?
- A. Хун дассан газартаа үлддэг жамтай юм гэж хэлэхийг зорьсон
B. Хүн байгаль хоёр бие биедээ найрсан шүтэн оршин тогтнодог гэж хэлэхийг зорьсон.
C. Байгалийн ер бусын үзэгдлийн тухай өгүүлэхийг зорьсон.
D. Хун өвөлжихөөр халуун орныг зорих тэнхээгүй болдог юм гэж хэлэхийг зорьсон.
E. Хун шувуу бол хүн шиг амьдарч чаддаг гэж хэлэхийг зорьсон.
8. “Харсаар байтал сүргээсээ нэг хун нь өдлөн нисэж чадахгүй болсныг улаан бургаст бүрдийн хөвөөг олон жил сахисан өвгөн эмгэн хоёр хараад, хөөрхий амьтныг араг хөмрөн барьж, гэртээ аваачин, хугарсан далийг нь чиг барин боожээ” гэсэн өгүүлбэрт сэтгэлийн ямар өнгө аяс илэрсэн бэ?
- A. Айсан өнгө аяс
B. Өрөвдсөн өнгө аяс
C. Уйтгарласан өнгө аяс
D. Цөхөрсөн өнгө аяс
E. Гунигласан өнгө аяс
9. Эхийн хэв маягийг зөв тодорхойлсныг олоорой.
- A. Тайлбарласан эх
D. Эргэцүүлсэн эх
- B. Тоочсон эх
E. Тоочиж, тайлбарласан эх
- C. Хүүрнэсэнэх
10. “Хун шувуу эдгэрсэн жигүүрээ тэнийлгэн нислээ” гэсэн өгүүлбэрээс гурван бүрэлдэхүүнт цөм бүтцийг олоорой.
- A. Хун шувуу нислээ.
B. Жигүүрээ тэнийлгэн нислээ.
C. Хун шувуу эдгэрчээ.
D. Хун шувуу жигүүрээ тэнийлгэлээ.
E. Жигүүр нь эдгэн нислээ.
11. Эхийн үйл явдлаасзүйлчилсэн утгаараа ялгаатай өгүүлбэрийг олоорой.
- A. Сэрүү орох
D. Бургасны үзүүрт бултайх
- B. Эрхи шиг хэлхэх
E. Хаврын урь орох
- C. Цас будрах

12. “Цагаан лянхуа дэлгэрсэн шиг тэр хүрээлэн дунд хар цэцэг шиг ганц хун нисэж буухыг...” гэсэн өгүүлбэрийн онцолсон холбоосыг тохирох үгээр солин найруулаарай.
A. авч
B. бөгөөд
C. чинээ
D. мэт
E. тухай
13. “Хөх бүрдэд хөхөө өвлийн гурван сар өнгөрч, хаврын урь улаан бургасны үзүүрт гөлөглөн бултайжээ” гэсэн өгүүлбэрийг салаалан хувиргасныг олоорой.
A. Хөх бүрдэд хүйтний ам цаашилж, модны үзүүрт урин цагийн өнгө тодорчээ.
B. Өвлийн сар өнгөрч, хаврын урь оржээ.
C. Улаан бургаст хөх бүрдэд хөхөө өвлийн гурван сар өнгөрсөн бөгөөд хаврын урьбургасны үзүүрт гөлөглөн бултайх ажээ.
D. Хаврын урь бургасны үзүүрт гөлөглөн бултайсан нь хөх бүрдэд өвөл өнгөрснийх.
E. Хөх бүрдэд хөхөө өвлийн гурван сар өнгөрч, хаврын урь улаан бургасны үзүүрт гөлөглөн бултайжээ.
14. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
A. Бурам амттай боловч буйгаар нь идэж болдоггүй.
B. Үнэр ялдам агь гангыг эзэгнэнхэн төрлөө, би
C. Найган ганхах цэцгийг намрын салхи үлээнэ.
D. Цаасан дээр мөртэй, цасан дээр нэртэй хүн шүү би.
E. Царайд нь улбар ягаан туяа тодрон, улам ч сайхан болов.
15. “Утаа үнэртсэн тулгат галын дэргэд жигүүрээ ээн хэвтэх болжээ” гэсэн өгүүлбэрийн байц гишүүнийг олоорой.
A. утаа
B. тулгат
C. галын дэргэд
D. жигүүрээ
E. үнэртсэн
16. “Хөх бүрдэд хөхөө өвлийн гурван сар **өнгөрч**, хаврын урь улаан бургасны үзүүрт гөлөглөн бултайв” гэсэн өгүүлбэрийн онцолсон өгүүлэхүүнийг яаж хувиргавал цагийн байц гишүүн өгүүлбэртэй УНӨ болох вэ?
A. өнгөрөнгөө
B. өнгөрдөг
C. өнгөрснийхойно
D. өнгөрөх
E. өнгөрөх шиг
17. “Нэг хун нь өдлөн нисэж чадахгүй болсныг өвгөн эмгэн хоёр харжээ” гэсэн өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.
A. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
B. Угсарсан нийлмэл өгүүлбэр
C. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
D. Энгийн өгүүлбэр
E. Холимог нийлмэл өгүүлбэр
18. Дараах холбоо үгийн бүтцийг ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг олоорой.
Хөх бүрд, галын дэргэд, олон жил, хөвөөг сахисан
A. хөхөө өвөл
B. намрын өдөр
C. орчлон хорвоо
D. эрхи шиг хэлхэх
E. бүрдээ тойрох
19. “Өвлийн сар” гэсэн холбоо үгийн харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утга нь аль вэ?
A. Уулюмхэний, юуны эзэмшилд буй утга
B. Орших байр, орон зай заасан утга
C. Бүхлийн хэсгийг заасан утга
D. Цаг хугацаа заасан утга
E. Шинж чанар заасан утга
20. Дараах холбоо үгийг ажиглаад, шууд утгаараа байгаа үгийг олоорой.
A. бор гэдсээ тэжээх
B. бов бор царайтай
C. хар бор ажил
D. бор хоолонд орох
E. бор дарсанд орох
21. Ойролцоо утгатай үгсийг олоорой.
A. эрт орой
B. буцах ирэх
C. унах гүйх
D. урд өмнө
E. үхэр туга

22. Ерийн, үүсмэл биш, ганц тоот, заахын тийн ялгал, эзэнд /ерөнхийлөн/ хамаатуулах нөхцөлтэй жинхэнэ нэрийг олоорой.
 А.тэнгэртээ В.цагаасаа С.жигүүрээ
 D.эгшнүүдийг E.тооноор
23. Үгийн бүтцээр зөв задалсныг олоорой.
 А.сүрэг+ээс+ээ В.сахь+0+сан С.эргэ+0+0+лд+сээр
 D.хүрээ+л+0+н E.ган+гана+0+0+н
24. “Дүү хичээлээ хийзэнэж л байг. Дүнгээ сонссоор сэтгэл амрав.Гэртээ хүүхдээ цоожлож үлдээж болохгүй. Тугалсан үнээгээ нэмнэе. Тоглож наадхад цаг гарга” гэсэн өгүүлбэрүүдэд зөв бичгийн дүрмийн алдаатай үг хэд байна вэ?
 А. 3 В. 5 С. 6 D. 7 E. 4
25. Дараах үгээс төрөл биш утгатай үгийг олоорой.
 А. бултга В. бултайх С. бултгана
 D. бултгар E. бултаараа
26. Үгсийн аймгаар зөв бүлэглэсэн нь аль вэ?
 А.хөөрхий, чиг, өндөр, шиг В.зөв, дунд, тэрхүү, утас
 С.хоёр, ганц, дөчин, цуваандаа D.дээгүүр, дунд, дэргэд, хойно
 E.сэрүү, улаан, зэврүүн, өдөр
27. Гурван үет бүлэг үгс нь аль вэ?
 А. болсныг, сахисан, амьтныг, хугарсан, хоёрын
 В. гөлөглөж, өвөлжсөн, жигүүрээ, сүвлэж, ганганан
 С. хуйсгануур, хэдэнтээ, шамбалын, мэдэхэд, эргэлдэн
 D. лянхуа, хүрээлэн, буухыг, бударганасан, тэнгэртээ
 E. дэлгэрсэн, хорвоогийн, хошууран, бүхийд, эрхи
28. Утгатөгсөгүүлбэрбүтээхэдцэгийнорондальбүтээврүүддарааллаараатохирохвэ?
 “Тэнгэр цэлий...нар ээ... үес хүн амь... налайна.”
 А.-ээд,-сэн,-р В.-н,-х,-тан С.-ж,-хлээр,-д
 D.-н,-нгээ,-тан E.-тэл,-мэгц,-ууд
29. Үйлээс нэр үг үүсгэх “-лт” дагаврыг**хамгийн оновчтой**найруулсан жишээг олоорой.
 А. Хичээл дээр уншилт хийв.
 В. Эмнэлэгт төрөлт болов.
 С. Тэдний ололтыг дэмжив.
 D. Олс суналт өгөв.
 E. Багш самбарт бодолт хийлээ.
30. Олон тооны дагаврыг зөв хэрэглэснийг олоорой.
 А. хэсэг адуунууд В. Булганчууд
 С. хос гуталнууд D. элснүүд нүүдэллэх
 E. миний хүслүүд
31. Найруулгын дээд, дунд, доод зэргээр **илрээгүй** бүлэг үгийг олоорой.
 А. сонор, чих, дэлдэн В. өргөө, гэр, овоохой
 С. үзэх, харах, гийх D. тэргүүн, толгой, бөндгөр
 E. зооглох, идэх, гудрах
32. Өргөдлийн найруулгад**хамааралгүй**үгийгсонгоорой.
 А. элсүүлэн суралцуулна уу. В. тогтоосугай С. Миний бие
 D. харгалзан үзэж E. өргөдөл гаргаса

33. “Дал мөр” гэсэн холбоо үгийн зөв бичсэнийг олоорой.

- | | | | | |
|------|----|------|----|------|
| A | B | C | D | E |
| DelO | Dæ | DelK | dæ | Delæ |

34. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- | | | | | |
|----------|---------|-------|-----------|---------|
| A | B | C | D | E |
| fKsokkba | YeBæseæ | CoBjO | NodeIdobt | Mærgo%t |

35. Цэгийн оронд тохирох дагаврыг нөхөж, зүйр цэцэн үг бүтээгээрэй.

- | | | | | | |
|-----------------------|----|-----|------|-----|-----|
| | A | B | C | D | E |
| foidemO | -æ | -la | -mjI | -II | -IO |
| SinO,,,Decjya,,,bETTI | | | | | |
| JesamI | | | | | |
| SidorgO | | | | | |
| Jiro^ | | | | | |
| bET | | | | | |
| ii | | | | | |

36. Монгол бичгээр бичсэн эхийг зөв хөрвүүлснийг олоорой.

- | | | | | | |
|----------------------|---------|---------|----------|---------|---------|
| | A | B | C | D | E |
| Kido)T bæ | Үнээнд | Үгэнд | Үнээнд | Үнэгэнд | Үнэгэнд |
| Sinokka dO Dorelejo | дөрлөж | дурлаж | дөрлүүлж | дурлаж | дурлаж |
| MæI bææ | морио | морио | мориор | морио | мориор |
| foinokka dO Dorelejo | Чимээнд | Чимгэнд | Чимээнд | Чөмгөнд | Чөмгөнд |
| | дөрлөж | дурлаж | дөрлүүлж | дурлаж | дурлаж |
| | хутгаа | хутгаа | хутгаар | хутгаа | хутгаар |

37. “Ногтолсон унага чинь
Ногтруунаас олон
Зэллэсэн унага чинь
Зээр гөрөөснөөс чинь олон болог!” гэсэн нь аман зохиолын ямар төрөл вэ?
A. Бэлгэ дэмбэрлийн үг B. Дом шившлэг C. Ертөнцийн гурав
D. Цэцэн үг E. Жороо үг
38. Д.Равжаагийн “Ичиг, ичиг” шүлгийн орхигдсон хэсгийг нөхөөрэй.
“Аяа бас, аавыгаа өргөхгүйохид ичиг”
A. өөрийгөө бодогч B. эрийг өргөгч C. бусдыг шоологч
D.хий гиюүрэгч E.дэмий сэлгүүцэгч
39. Ус нь намайг угаах гэж
Эрэг дээгүүрээ цоройж
Эх орон над руу ирсэн
Уул нь намайг үнэсэх гэж
Манан дээгүүрээ цоройж
Эх орон над руу ирсэн. (Б.Лхагвасүрэн)
Шүлгийн тодруулсан мөрд ямар дүрслэх хэрэглүүр илэрсэн бэ?
A. Адилтгал B. Төлөөлөл C. Зүйрлэл
D. Ихэсгэл E. Хүншүүлэл
- 40.Ишданзанванжилын “Гүнгийн зуугийн гэгээний Алтан сургаал”-аас өөрийн үүрэг зорилгоо умартсан төрийн эрх мэдэлтнүүдийг шүүмжлэн ёгтолсон утгатай хэсгийг олж тэмдэглэнэ үү.
A. Аж ахуй ариутгах суртал үгүй өсгөвөл
Аавын хишиг барагдаж, дутал зовлон үзмүй.
B. Тал найр, өнгө мөнгө, самуурлыг дагавал
Таван хэргийг ч таслах тамир үгүй зөнөмүй.
C. Чадал тамир бадрах арван наснаас дээш
Чанга зориг эхэлж, сургаал үл авмой.
D. Өтлөгсөд өвдөхүл нас нас хэмээлдэн
Үхэхийг бэлдэж, арвидахыг сэтгэмүй
E. Хочлолдон эвдрэхийн шалтгаан дор хүрвэл
Гутамшигт зовлонг бүгдээр хүртмүй.

ХОЁРДУГААР ХЭСЭГ (Харгалзуулах даалгавар)**Санамж:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Хэлцийг ойролцоо утгаарньзөвхаргалзуулаарай.

- | | |
|---------------------------------|-----------------------------------|
| a. Ус ууж, өвс идсэн юм шиг | 1. Өлөн гэдэс өвчүүтэйгээ наалдах |
| b. Угалзан эвэр ухархайд нь | 2. Гэм нь урдаа, гэмшил нь хойноо |
| c. Дотор газраас өр нэхэх | 3. Гар бариад бугуй барих |
| d. Өглөө босоод мануухай босгох | 4. Найман ясанд хэлхсэн |
| e. Түрүүний бөөс толгойд гарах | 5. Муу санаа биеэ отно |

2.2 Зохиолын өгүүлэгдэхүүний бүрдэл хэсгүүдийн тодорхойлолтыг зөв хариутай нь харгалзуулаарай.

- | | |
|-------------|---|
| a. Төгсгөл | 1. Зохиолын эхлэл хэсгийг залган хөгжүүлж, улмаар зөрчил үүсгэн, үйл явдлын цаашдын өрнөх шалтгаан болж буй хэсэг |
| b. Эхлэл | 2. Зохиолын үйл явдал, зөрчил тэмцэл алгуур хөгжсөөр цаашид үргэлжлэх аргагүй болтлоо хурцдаж, дээд цэгтээ хүрсэн хэсэг |
| c. Зангилаа | 3. Өгүүлэгдэхүүний өрнөх дэвсгэр суурь бөгөөд цаашид зохиолын зөрчил, тэмцэл гарах ахуй амьдрал, нийгмийн нөхцөл, гол баатруудын тухай танилцуулдаг хэсэг |
| d. Туйл | 4. Зохиолчийн өөрийн үнэлэмж, хандлага, дүгнэлт бүхий хэсэг |
| e. Өрнөл | 5. Зангилаа бий болсноос хойш тэрхүү эгзэгтэй зангилааны учир зүйг олохын тулд чөлөөтэй өрнөж буй хэсэг |

2.3 Үгийг тайлбартай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|-------------------|--|
| a. хялмаа | 1. том том ширхэгтэй цас ихээр малгайлан орох |
| b. хунгар цас | 2. хүйтэн цагт цав цайн газарт буух цас |
| c. хуурай цас | 3. талст бүхий нурж бутран унах цас |
| d. малгайлсан цас | 4. том ширхэгтэй цас |
| e. лавсаа цас | 5. салхи шуурганд хийсэж хуралдан хатуурч хөрөлсөн цас |

2.4 Зөвийг нь олж харгалзуулаарай.

		1	2	3	4	5
a	Цагт нэрийн "сан ⁴ " дагаврыг буруу залгаж бичсэн үг	явсныг	очсноос	хаасны	олдсоныг	хөвснөөр
b	"ыг" нөхцөлийг бичих үг	гавж	хуш	унь	гуч	орц
c	Үйлийнболзохтийн ялгалын "-вал ⁴ " нөхцөлөөр хувилах үг	сал	өг	хуул	хөв	чим
d	Балархай эгшиг нь гээгдэх үг	ахиц+аар	сонин+оос	хоног+ийн	үүрэг+ээр	нөхцөл+ийг
e	Тусгаарлахүүрэгтэй орсон "ь"-тэй үг	хольё	тавья	харья	сахья	хэлье